



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/112

Чингис хот

**Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгт
хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.10 дахь заалт, аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/136 тоот захирамж, Хэрлэн сумын Онцгой комиссын 3 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн 4.8.1.1 дэх заалтын хүрээнд Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт, ой хээрийн гал түймэр, үер ус, зудын бэлтгэл бэлэн байдлыг хангуулах зорилгоор гамшгийн бэлэн байдлын үзлэгийг 2025 оны 03 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Тус гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулагдахтай холбогдуулан шуурхай штабын байрыг бэлтгэх, сумын онцгой комисс, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд тодотгол хийн, төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллахыг Шуурхай штабын дарга (Г.Лхагвабаатар)-д үүрэг болгосугай.

3. Бэлэн байдлын үзлэгт шаардлага галын өрөөний гал унтраах багаж тоног төхөөрөмж, болон нэмж авах бараа материалд зарцуулагдах зардлыг хавсралтаар баталсугай

4. Бэлэн байдлын үзлэгт шаардагдах 32.942.500 (гучин хоёр сая есөн зуун дөчин хоёр мянга таван зуу) төгрөгийг Гамшгийн эрсдэлийн сангаас гаргахыг сумын Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Д.Баярцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР

Хэрлэн сумын Засаг даргын 2025 оны
04 дугаар сарын 24-ны өдрийн 17/1.12
дугаар захирамжийн хавсралт

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгт шаардлагатай тоног төхөөрөмж,
багаж хэрэгсэл, хувцас, эд хэрэгслийн зардлын тооцоо

д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ	Бэлтгэн нийлүүлэгчид
1	Мотор	1	960,000	960,000	Л.Тунгалаг
2	Сүх	1	38,500	38,500	
3	Галын хор	3	30,000	90,000	
4	Станц	10	240,900	2,409,000	
5	Гар чийдэн	4	15,000	60,000	
6	Моторт хөрөө	1	300,000	300,000	
7	Цуравдагч	1	350,000	350,000	
8	Рло	9	580,000	5,220,000	
9	Галын бээлий	12	65,000	780,000	
10	Нимгэн галын хувцас	10	200,000	2,000,000	
11	Эвхдэг ор	4	155,000	620,000	
12	Хээрийн эвхдэг ширээ	1	150,000	150,000	
13	Хээрийн эвхдэг сандал	4	45,000	180,000	
14	Баг камержуулалт	6	1,500,000	9,000,000	
				22,157,500	
15	Хантааз	45	8,000	360,000	"Узат" ХХК
16	Хантааз	15	5,000	75,000	"Хэнтий Нүнжиг" ХХК
17	Дрон	1	5,000,000	5,000,000	hobbyzone онлайн дэлгүүр утас: 80034339
18	Шатахуун	1	3,000,000	3,000,000	"Хангарьд" ХХК
19	Эмнэлэгийн майхан 4х6	1	2,350,000	2,350,000	"Уран зол урлан" ХХК РД65952027
	Нийт дүн			32,942,500	